

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН БИЧИЛ УУРХАЙГААР  
АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ

2019 он

№ 2019/02

Эрдэнэ сум

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Дорноговь аймаг (хот)-ийн Эрдэнэ сум, (дүүрэг)-ын Засаг дарга Э.Ганбаяр (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас “.....~~Дулааба Түвшин~~ нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн дарга (албан тушаал) .....~~С. Оюун Бат~~ нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) Эрдэнэ сум (дүүрэг)-д байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн (дүүрэг)-ийн Хунхат нэртэй газарт орших 5 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл нэг жилийн бичил уурхай (жоншны төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагааг эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож, сагандартын дагуу савтай болох.

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6 Журмын 2.2.2-т заасаны дагуу тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн иргэнийг тухайн талбайд ажиллуулахад хяналт тавих.

2.1.7. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.8. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.9. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

2.1.10 Бичил уурхай эрхлэгчид Байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг ажлын 5 хоногт багтаан батлуулж барьцаа хөрөнгийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх.

#### **Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг**

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

---

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзолгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-г заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см<sup>3</sup> хүртэлх багтаамжтай логоод шаталгат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11 Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.

3.1.12. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах 2000.000 /  
100 06 12 55408 / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.13. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.14. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.15. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;

---

3.1.16. ажилтнуудтай хөлөмөрнийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх;

3.1.17 шаардлагатай хүний нөөц бүрдүүлэхэд оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх.

3.1.18 Орон нутгийн амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 2 өрхөд дэмжлэг үзүүлэх.

3.1.19 Орон нутгийн ажилгүй иргэдийг ажлын байраар хангах

3.1.20 Орон нутагт нийгмийн хариуцлага хүлээж тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэх.